



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 10 өдөр

Дугаар А/14

Булган сум

“Стратеги төлөвлөгөөний төсөл” боловсруулах ажлын хэсгийг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэг, Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн 2025-2028 оны “Стратеги төлөвлөгөөний төсөл” боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга: Д.Алтаншагай (Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: Ч.Цогбуян (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Г.Баасанжаргал (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Б.Насанжаргал (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтсийн Шийдвэрийн биелэлтийн хяналт-шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн)

Б.Бат-Эрдэнэ (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтсийн Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн)

Б.Отгонсүвд (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Тайлан мэдээ, тогтоол шийдвэр хариуцсан мэргэжилтэн)

М.Энхжаргал (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Гадаад

харилцааны бодлого хариуцсан мэргэжилтэн)
Б.Энхмаа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн
захиргааны удирдлагын хэлтсийн Өргөдөл гомдол,
мэдээллийн ил тод байдал, цахим үйлчилгээ хариуцсан
мэргэжилтэн)

Э.Хосбаяр (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хүний нөөцийн
бодлого хариуцсан ахлах мэргэжилтэн)

А.Сарантуяа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Нутгийн
захиргааны бодлого, дотоод ажил хариуцсан
мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Д.Эрдэнэбилэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн
дарга)

2.Стратеги төлөвлөгөөний төслийг боловсруулахдаа Засгийн газрын Хэрэг эрхлэх
газрын даргын 2020 оны 100 дугаар тушаал “ Аргачлал, загвар” болон бусад холбогдох
хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч
(Д.Алтаншагай)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР